

## ЭМГ-ын 7 хоногийн мэдээ

### I. Зарим статистик үзүүлэлтүүд

- Нийт төрөлт 73
- Амьд төрөлт 73
- Амьгүй төрөлт 0
- Дутуу төрөлт 2
- Нялхсын эндэгдэл 0
- 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2
- 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл
- Эхийн ноцтой хүндрэл 0
- Төрөлхийн гажиг 0
- Гэрийн төрөлт 0
- Ихэр-0

15-39 насны хүн амд гепатитийн В, С вирусийн илрүүлэг, оношилгоог хийх “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” хөтөлбөрийн 2 дахь шатны нээлтийн үйл ажиллагааг аймгийн спорт цогцолборт зохион байгуулж, 305 хүнийг хамрууллаа. Орон нутгийн ХМХ-ээр “Саян”, “Дербес,” радиогоор зарлал мэдээлэл өгч, 37 агентлагуудад урилга тараан, 500 ширхэг элэгний гарын авлагыг тараан түгээсэн.

Нээлтийн үйл ажиллагаанд аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан, аймгийн Засаг даргын орлогч А.Камелият, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга К.Бекжан, Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Х.Манчук, Өлгий сумын

ИТХ-ын дарга Х.Даулетбек, Эрүүл мэндийн газрын дарга С.Айгүл, Нийгмийн даатгалын хэлтсийн эрүүл мэндийн даатгалын тасгийн дарга Б.Асель нар оролцож, “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлж байгаа эмийн хөнгөлөлт, оношлогоо, эмчилгээний талаар онцолж, зорилтот насны хүмүүсийг бүрэн хамруулах чиглэлээр анхаарч ажиллахыг эрүүл мэндийн салбарын ажилтан албан хаагч нарт анхаарууллаа.

Энэхүү хөтөлбөрийг хүрээнд Баян-Өлгий аймгийн 15-65 насны 43 мянган иргэн оношлогоо, эмчилгээнд хамрагдах ёстой бөгөөд өнөөдрийн байдлаар 7 мянган иргэн хамрагдсан байна.

5-бүрэн дунд сургуулийн 70 багш ажилчдад “Нийгмийн эрүүл мэндийн хүртээмж ” сэдвээр сургалт явуулсан.

Бугат сумын ЭМТ-ийн 20 эмч ажилчдад ёс зүйн чиглэлээр сургалт явуулсан.Ногооннуур сумын сум дундын эмнэлгийн 16 эмч ажилтанд НЭМ-ийн чиглэлээр сургалт явуулсан.

Аймгийн төвийн 1-18-р цэцэрлэгийн хүүхдүүдийн эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, ирцийн тандалт хийсэн. Үүнд 60 хувийн ирцтэй байсан ба ирцийн хувь бага байгаа шалтгаан нь сурагчдын амралттай холбоотой байсан. Томуугийн шалтгаантай 5%-тай байсан. Мөн цэцэрлэгийн багш, ажилчидад өглөө бүр хүүхдийг бүргэж ирээгүй тохиолдолд шалтгааныг тодруулж байх, өвчлөл бүртгэгдсэн ангид өрхийн эмчтэй хамтран томуу өвчний шинж тэмдгийг эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулж, өглөөд хүүхэд хүлээж авахдаа үзлэг, тандалт хийж, сэжигтэй болон өвчилсөн хүүхдийг эрт илрүүлэн, тусгаарлах, өрөө тасалгаанд чийгтэй цэвэрлэгээг хийн, 2 цаг тутамд агаарын солилцоо хийх анги танхимын дулааныг 18-20 хэмд тогтмол байлгах талаар зөвлөлөгөө өгч арга зүйгээр ханган ажилласан. Тандалт хийсэн цэцэрлэгүүдийн багш, ажилчидад томуугийн цэгэн массажийг өглөө, орой бүр хийх аргад зааж сургасан .

Дарын хувийн цэцэрлэг болон 2-р цэцэрлэгийн нийт 22 багш ажилчдад цэгэн массаж хийх аргачлал, томуугаас хэрхэн урьдчилан сэргийлэх талаарх сургалт явуулсан.

АНЭ-ийн хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлж буй 7 хүүхдээс хамрын арчдасын сорьц авч ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид хүргүүлж, томуугийн А хүрээний вирус илэрч, харъяа байгууллагуудад эргэн мэдээлсэн.

2013 оны 358 дугаар тушаалын дагуу ЭМЯ-наас томуугийн дэгдэлтийн үед илүү цагаар ажилласан эмч, ажилчдад илүү цагийн хөлс олгох бичиг ирсэнтэй холбогдуулан 2017 оны 09 сараас 2018 оны 03 дугаар сар хүртэлх Томуу, томуу төст өвчний статистик мэдээг гаргаж, дүгнэлт хийсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, 340-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор 2018 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 15:00 цагт Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио дуугарахад албаны бүрэлдэхүүн болон байгууллагын бүх ажилчдыг сонгосон газар зүйн байр болох аюулгүй талбайд нүүлгэн шилжүүлэх дадлага сургуулилтыг зохион байгуулав .

1. Дэлүүн сумын сум дундын эмнэлэгт ЭТХ ийн зөвлөн туслах баг очиж 3 хоног ажиллаж арга зүйн зөвөлгөө өгсөн
2. УМХЕГ-ын улсын байцаагч нартай хамтарч ЭТХийн хэлтийн дарга мэргэжилтэн нар 1 хоног хяналт үнэлгээ хийв.
3. Олон улсын эмч нарын баярыг тохиолдуулан БӨ аймгийн “ЭМ холбоо” НЭ,Сум ӨЭМТ, хувийн эмнэлгүүдийн эмчнарын дунд сагсан бөмбөг, гар бөмбөг,шатарын тэмцээн зохион байгуулав.
4. Ард иргэд болон эмнэлгийн мэргэжилтэнүүдийн дунд “Антибиотик эмийн даслаас урьдчилан сэргийлэх” “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх” 1 сарын аян зохион байгуулсан.

ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧИН “(ТТӨ)-ИЙ ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ

МЭДЭЭ АМБУЛАТОРИД СУУРИЛСАН ТАНДАЛТ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 13дугаар долоо хоногт нийт 4161хүн үйлчлүүлсний289 (6.9%)нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1%-иарбуурсанүзүүлэлтэй байна.

ХОЁР.ЭМНЭЛЭГТ СУУРИЛСАН ТАНДАЛТ

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (205)-ийн дотор 31 буюу 15.1%-ийг эзэлж,өмнөх долоо хоногтой харьцуулахад14.9%-иар буурсанүзүүлэлтэй байна. Уушгины үрэвслийн шалтгаантай нас баралт бүртгэгдээгүй байна.

ГУРАВ. ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ДУУДЛАГА

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн368 дуудлагын100(27.1 %) -ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлжбайна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 2,4 %-иар буурсанүзүүлэлтэй байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 13дугаар 7 хоногт аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын тандалтын нэгжүүд Томуу, томуу төст өвчний тохиолдол 18 удаа ирүүлэхээс 18(100%) удаа ирүүлсэн байна.

ИРҮҮЛЭЛТ, ТАНДАЛТЫН НЭГЖЭЭР / 2018 ОНЫ 13ДАХ 7 ХОНОГИЙН БАЙДЛААР/

| Д/Д | Тандалтын нэгж | Ирвэл зохих | Ирсэн |      | Хугацаандаа ирсэн |      | Хоцорч ирсэн |      |
|-----|----------------|-------------|-------|------|-------------------|------|--------------|------|
|     |                |             | Тоо   | Хувь | Тоо               | Хувь | Тоо          | Хувь |
| 1   | Алтай          | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 2   | Алтанцөгц      | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 3   | Дэлүүн         | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 4   | Булган         | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 5   | Сагсай         | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 6   | Улаанхус       | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 7   | Цэнгэл         | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 8   | Буянт          | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 9   | Толбо          | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 10  | Ногооннуур     | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 11  | Цагааннуур     | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 12  | Баяннуур       | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |
| 13  | Бугат          | 13          | 13    | 100% | 13                | 100% | 13           | 0%   |

|    |         |     |     |      |     |      |     |    |
|----|---------|-----|-----|------|-----|------|-----|----|
| 14 | Жансая  | 13  | 13  | 100% | 13  | 100% | 13  | 0% |
| 15 | Мейрим  | 13  | 13  | 100% | 13  | 100% | 13  | 0% |
| 16 | Раушан  | 13  | 13  | 100% | 13  | 100% | 13  | 0% |
| 17 | Шипагер | 13  | 13  | 100% | 13  | 100% | 13  | 0% |
| 18 | НЭ      | 13  | 13  | 100% | 13  | 100% | 13  | 0% |
|    | Нийт    | 234 | 234 | 100% | 234 | 100% | 234 | 0% |

ЭМНЭЛЭГ, СУМ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮД ТОМУУ, ТОМУУ ТӨСТ ӨВЧНИЙ ТОМУУГИЙН ХАРУУЛДАН ТАНДАЛТЫН 13 ДАХ 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

| Д/Д | Эрүүл мэндийн байгууллага | Нийт үзлэг | Томуу,т омуу төст өвчний тохиолдол | Эзлэх хувь | Өмнөх долоо хоногтой харьцуулбал | Түргэн тусламжийн дуудлага | Томуу төст өвчний дуудлага | Түргэн тусламжийн Эзлэх хувь | Өмнөх долоо хоногтой харьцуулбал |
|-----|---------------------------|------------|------------------------------------|------------|----------------------------------|----------------------------|----------------------------|------------------------------|----------------------------------|
| 1   | Алтай                     | 199        | 13                                 | 6.5%       | 13.1%                            | 16                         | 4                          | 25%                          | 41%                              |
| 2   | Алтанцөгц                 | 40         | 10                                 | 25%        | 30.4%                            | 10                         | 10                         | 100%                         | 31.2%                            |
| 3   | Булган                    | 80         | 4                                  | 5%         | 2.5%                             | 15                         | 0                          | 0%                           | 0%                               |
| 4   | Баяннуур                  | 104        | 4                                  | 3.8%       | 12,8%                            | 12                         | 0                          | 0%                           | 55,5%                            |
| 5   | Бугат                     | 44         | 3                                  | 6.8%       | 9.4%                             | 14                         | 0                          | 0%                           | 0%                               |
| 6   | Буянт                     | 212        | 9                                  | 4.2%       | 4.7%                             | 8                          | 2                          | 25%                          | 12.5%                            |
| 7   | Дэлүүн                    | 212        | 20                                 | 9.4%       | 9.4%                             | 37                         | 5                          | 13.5%                        | 20%                              |
| 8   | Ногооннуур                | 86         | 5                                  | 5.8%       | 5%                               | 23                         | 1                          | 4.3%                         | 2.5%                             |
| 9   | Сагсай                    | 35         | 15                                 | 42.8%      | 36.5%                            | 13                         | 4                          | 30.7%                        | 9.5%                             |
| 10  | Толбо                     | 42         | 5                                  | 11.9%      | 10.3%                            | 4                          | 1                          | 25%                          | 0%                               |
| 11  | Улаанхус                  | 129        | 25                                 | 19.3%      | 11.4%                            | 41                         | 11                         | 26.8%                        | 28.5%                            |
| 12  | Цагааннуур                | 80         | 13                                 | 16.2%      | 22%                              | 7                          | 0                          | 0%                           | 70.5%                            |
| 13  | Цэнгэл                    | 280        | 79                                 | 28.2%      | 13.1%                            | 33                         | 23                         | 69.6%                        | 10%                              |
| 14  | Жансая                    | 140        | 12                                 | 8.5%       | 13.1%                            | 0                          | 0                          | 0%                           | 0%                               |
| 15  | Мейрим                    | 636        | 14                                 | 2.2%       | 3.5%                             | 3                          | 0                          | 0%                           | 0%                               |
| 16  | Рауан                     | 292        | 10                                 | 3.4%       | 7%                               | 6                          | 6                          | 100%                         | 0%                               |
| 17  | Шипагер                   | 503        | 1                                  | 0.1%       | 0%                               | 0                          | 0                          | 0%                           | 0%                               |

|      |                                      |      |     |       |      |     |     |       |       |
|------|--------------------------------------|------|-----|-------|------|-----|-----|-------|-------|
| 18   | Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үзлэг | 1224 | 47  | 3.8%  | 6.8% | 126 | 33  | 26.1% | 39%   |
|      | Эмнэлэгт хэвтэгсэд                   | 205  | 31  | 15.1% | 30%  |     |     |       |       |
| Нийт | Аймгийн хэмжээнд                     | 4161 | 289 | 6.9%  | 7.9% | 368 | 100 | 27.1% | 29.5% |

Аймгийн хэмжээнд 12дах долоо хоногт тандалтын нэгжүүдээс мэдээ ирүүлэлтийн байдал 100% -тай байсан бол 2018 оны 13дах долоо хоногт мэдээ ирүүлэлт 100% -тай байна.